

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг нь Япон улсын Токио хотын технологийн институтын судлаач др.Шигэрү Какүмото, Японы Осака сангёо их сургуулийн ерөнхийлөгч профессор Ёошикава Кожи нарыг хүлээн авч уулзаж нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлд харилцан туршлага судалсан.

Уулзалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 11 цагаас Хангарьд ордны 14 давхрын “А” зааланд хүлээн авч уулзсан бөгөөд дараах албан хаагчид оролцсон.

1. Газрын дарга О.Чинзориг
2. Төслийн хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ
3. Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ариунзаяа
4. Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Туяацэцэг
5. Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Эрдэнэцэцэг
6. Төслийн хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Батнавч

Шигэрү Какүмото нь анхны автомашины газрын зургийн системийг зохиож хөгжүүлж байсан бөгөөд Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг арилгах чиглэлд радио давтамж тодорхойлох RFID төхөөрөмжийг хэрэглээнд нэвтрүүлэхэд тулгарч болзошгүй эрсдэл, түүнийг залруулах боломж, хотын төвийн тойрсон түгжрэлийг бүүсгэж буй уулзвар, гэрлэн дохионы систем дээр түлхүү анхаарч ажиллах талаар зөвлөгөө өгсөн.

Мөн Японы Осака хот нь авто замын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэсэн шийдлийн талаар танилцуусан бөгөөд уг шийдэл нь хотын төвийн урсгалын чиглэлд өөрчлөлт оруулж нэг чигийн урсгалтай болгосон шийдэл юм.





Гарсан үр дүн:

1. Түгжрэл бууруулах чиглэлд Японы Осака болон бусад хотын туршлагад үндэслэн зөвлөгөө авах

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.САЙНХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.АРИУНЗАЯА